

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ДУГААР	151021-5
ХАВСРАЛТ	1
ОГНОО	2022 оны 02-р сарын 25-ны өдөр
УТГА	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)–ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (“Хурал”)–ыг зарлан хуралдуулах асуудлыг хэлэлцээд Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дох заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дох заалт, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.9, 62.1.14 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын холбогдох заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хурлыг 2022 оны 04-р сарын 23-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19А, Шангри-Ла зочид буудал, 1-р давхрын хурлын танхимд хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хуралд дараах асуудлыг танилцуулахаар шийдвэрлэсүгэй. Үүнд:
  - (i) Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
  - (ii) Компанийн 2021 оны санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
  - (iii) Компанийн 2021 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)–ийн шийдвэр, түүний шалтгааныг танилцуулах.
3. Хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр шийдвэрлэсүгэй. Үүнд:
  - (i) Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ–ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
  - (ii) Дор дурдсан нэр дэвшигчдийг ТУЗ–ийн ердийн гишүүдээр сонгох. Үүнд:
    - (a) Адилбиш овогтой Ганхуяг;
    - (б) Адилбиш овогтой Ганболд;
    - (в) Гансүх овогтой Бат-Эрдэнэ;
    - (г) Очирбат овогтой Батмөнх;
    - (д) Ганболд овогтой Чинзориг; болон
    - (e) Болдбаатар овогтой Бат-Эрдэнэ;

ДУГААР 151021-5  
огноо 2022 оны 02-р сарын 25-ны өдөр

- (iii) Дор дурдсан нэр дэвшигчдийг ТУЗ-ийн хараат бус гишүүдээр сонгох. Үүнд:
  - (a) Нямжав овогтой Энхболд;
  - (б) Чулуун овогтой Мэргэн; болон
  - (в) Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo).
- 4. Хурлын зарыг 2022 оны 03-р сарын 02-ны өдөр, давтан зарыг 2022 оны 03-р сарын 17-ны өдөр тус тус өдөр тутмын сонин, Компани болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэсүгэй.
- 5. Хурлын зар, Хурлаар хэлэлцэх асуудлаар санал өгөх саналын хуудасны загвар, Хурлаас гарах шийдвэр болон Хуралтай холбоотой бусад материалыг тусгасан Хурлын материалыг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
- 6. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 03-р сарын 17-ны өдрөөр тогтсугай.
- 7. Хурлын зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлсэн өдрөөс эхлэн Хурал хуралдуулахтай холбоотой дор дурдсан баримт бичигтэй танилцах (тогтоолын 7(iv)-т заасан баримт бичгийн хувьд Хурлын үеэр) боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгосугай. Үүнд:
  - (i) Хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол;
  - (ii) Хурлын зар;
  - (iii) Хурлаас гарах шийдвэрүүдийн төсөл;
  - (iv) Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
  - (v) ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
  - (vi) Хурлын саналын хуудасны загвар; болон
  - (vii) Хуралд урьдчилан цахимаар санал өгөх заавар.
- 8. Хурлын даргаар ТУЗ-ийн дарга А.Ганхуягийг томилсугай.
- 9. Дор дурдсан нэр бүхий ажилтнуудыг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
  - (i) С.Дашдорж, Захирал, Санхүүгийн газар (дарга);
  - (ii) Т.Гантулга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;
  - (iii) Г.Батбаатар, Захирал, Маркетингийн газар; болон
  - (iv) Г.Энхтуяа, Комплаинс менежер.

ДУГААР 151021-5  
огноо 2022 оны 02-р сарын 25-ны өдөр

10. Дор дурдсан нэр бүхий хүмүүсийг Хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
  - (i) Б.Тэлмэн, Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Хөрөнгө оруулалтын шинжээч (дарга);
  - (ii) Ж.Мөнхзаяа, Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Брокер (гишүүн); болон
  - (iii) Э.Намуун, Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Брокер (гишүүн).
11. Хурлын материалыг 2022 оны 03-р сарын 02-ны өдөр брокерын компаниуд болох Голомт Капитал ҮЦК ХХК болон Алекс Капитал ҮЦК ХХК-д хүргүүлсүгэй.
12. Хуралд урьдчилан санал өгөх хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг 2022 оны 03-р сарын 21-ний өдрөөс 04-р сарын 22-ны өдрийн хооронд <https://hural.cumongol.mn> веб хаягаар хийж, санал өгөх линк, нууц кодыг хувьцаа эзэмшигчдийн гар утсанд илгээсний үндсэн дээр дээрх өдрүүдэд цахимаар хүлээн авахаар шийдвэрлэсүгэй.
13. Хурлын бэлтгэл ажлыг хангах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, энэ тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
14. Хурлын мэдэгдлийг 2022 оны 02-р сарын 28-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

*(Гарын үсгийн хуудас дагалдана)*

ДУГААР 151021-5  
 огноо 2022 оны 02-р сарын 25-ны өдөр

		ЗӨВШӨӨРСӨН	ТАТГАЛЗСАН	ТҮДГЭЛЗСЭН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:	 А. АНХУЯГ <b>СЭНТРАЛ            ЭКСПРЕСС            СИ ВИ ЭС            ХК</b> А. АНБОЛД <small>УЛААНБААТАР ХОТ            9022010246 6166804 ШЖР0471</small>			
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:	О. БАТМӨНХ			
	Г. БАТ-ЭРДЭНЭ			
	Г. ЧИНЗОРИГ			
	Б. БАТ-ЭРДЭНЭ			
	ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:	Н. ЭНХБОЛД		
	Ч. МЭРГЭН			
	ГАРИ СТИВЕН БИОНДО			
ТОГТООЛЫН БАТЛАГДСАН ХУВЬ:		100%		